



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Ногдол ашиг хуваарилах тухай”

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.1 дэхь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.10, 9.13 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 сарын 14-ний өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн 2023 оны ногдол ашгийг татвар төлсний дараахь цэвэр ашгаас хуваарилж олгосугай.
2. Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 1000 /Нэг мянга/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өдрөөс эхлэн компани дээрээс олгосугай.
5. Дээрх хугацаанд аваагүй ногдол ашгийн үлдэгдлийг ҮЦТХТ ТӨХХК-д байрлах компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
6. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж компанийн хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу ногдол ашиг олгох, эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулах, төлбөр тооцоо хийж гүйцэтгэх, ногдол ашгийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Д. Ганцэцэг, Бизнес хөгжил, санхүү хариуцсан захирал С. Дашдулам нарт үүрэг болгосугай.
8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ын Аудитын хороо /Ж.Баярсайхан/-нд үүрэг болгосугай.

ТУЗ-ЫН ДАРГА *Т. Тунгалаг* ТУНГАЛАГ

